



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар A/111

Арвайхээр

Журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Засгийн газрын “Түүхт ой, тэмдэглэлт өдрийн журам батлах тухай” 2010 оны 172 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тэмдэглэлт өдрийн тогтоох тухай” 2018 оны 07/02 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аймаг байгуулагдсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Уг журмын биелэлтийг ханган, шаардагдах төсвийг жил бүр батлуулан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100252

Аймгийн Засаг даргын 2019... оны 03.
дугаар сарын 05.ны өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

АЙМАГ БАЙГУУЛАГДСАН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тэмдэглэлт өдөр тогтоох тухай” 2018 оны 07/02 дугаар тогтоолын дагуу БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 7 дугаар тогтоолоор Өвөрхангай аймаг байгуулагдсан өдөр /цаашид “тэмдэглэлт өдөр” гэх/ буюу 2 дугаар сарын 18-ны өдрийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхэд оршино.

ХОЁР. Хугацаа

2.1. Өвөрхангай аймаг байгуулагдсан тэмдэглэлт өдрийг жил бүр тэмдэглэнэ.

ГУРАВ. Аймаг байгуулагдсан өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаа

3.1. Тэмдэглэлт өдрийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж болно.

3.2. Ажлын хэсэг нь тэмдэглэлт өдрийг өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж болно.

3.3. Тэмдэглэлт өдрөөр төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулан ажиллана.

3.4. Тэмдэглэлт өдрийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

3.4.1 Аймгийн үүсэл хөгжил, түүхэн замналыг залуу ҳойч үедээ сурталчилан таниулах ажлыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулах

3.4.2 Түүхэн өдрийн агуулга, ач холбогдол, олон нийтэд мэдээлж сурталчилах, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр түүхэн үйл явцыг сурталчилах нэвтрүүлэг, ярилцагаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх

3.4.3 Тэмдэглэлт өдрийг угтан өрөнхий боловсролын сургуулиудад аймгийн түүх, хөгжил дэвшлийн талаар сургалт, илтгэл, гар зураг, мэтгэлцээн зэргийг зохион байгуулах, судлаач, эрдэмтдээр дамжуулан иргэдэд аймгийн түүхийн талаар мэдээлэл хүргэх

3.4.4 Уралдаан, тэмцээн, өдөрлөг, аялал зэрэг урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах

3.4.5 Үндэсний бөхийн барилдааныг уламжлалт цагаан сарын барилдаантай хамтатган тэмдэглэх, хүндэтгэлийн цэцэг өргөх ёслолыг зохион байгуулах

3.4.6 Өнгөрөгч онд ажил үйлсээрээ шалгарсан тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, аварга ажилтнуудыг шагнаж урамшуулж, “Аймгийн

алдартан” тэмдгээр иргэдийг шагнах, амжилт бүтээлийг олон нийтэд сурталчилах, түгээн дэлгэрүүлэх

3.4.7 Иргэдэд төрийн нээлттэй үйлчилгээг хүргэх, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх

3.4.8 Бусад арга хэмжээ

3.5. Аймаг байгуулагдсан тэгш ой тохиосон жилүүдэд дараах ажлыг зохион байгуулна.

3.5.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүндэтгэлийн хуралдааныг зохион байгуулах

3.5.2 Аймгийн түүхийн талаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах

3.5.3 Аймгийн түүхэн ойтой холбоотой ном, зохиол, баримтат кино бүтээх, нэвтрүүлэг хийх

3.5.4 Хөшөө, дурсгал бүтээх, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах

3.6. Тэмдэглэлт өдрийг зохион байгуулах зардлыг орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, иргэдийн хандив тусламж, ивээн тэтгэгчдийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

-оОо-